



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/613

Булган сум

Тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих гэрээ байгуулах, эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 291 дүгээр зүйлийн 291.7 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Тусгай зориулалтаар 2023 онд агнах, барих агнуурын амьтны тоо толгойг тогтоох тухай” 444 дүгээр тогтоол, 2023 оны “Амьтны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоол, “Босго үнийн хэмжээ тогтоох тухай” 261 дүгээр тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны “Хуваарь батлах тухай” А/182 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих зөвшөөрөл олгох дуудлага худалдааны нэр бүхий ялагчийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих зөвшөөрөл олгох дуудлага худалдааны нэр бүхий ялагчтай “Тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих” гэрээ байгуулж, тусгай зориулалтын агнуурын амьтныг агнах зөвшөөрлийн үнэ, төлбөр хураамжийг хуульд заасан хугацаанд, холбогдох дансанд төвлөрүүлж, дуудлага худалдааны ялагч нарт тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023. оны
08 дугаар сарын 28-ны өдрийн А/Б/З дугаар
захирамжийн хавсралт

ТЭШИГ СУМЫН ЗАГАС АГНУУРЫН БҮС НУТГААС ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР ТУЛ
ЗАГАС БАРЬЖ БУЦААН ТАВИХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ДУУДЛАГА ХУДАЛДААНД
ЯЛАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

д/д	Ялагч Байгууллагын нэр	Амьтны зүйлийн нэр	Дуудлага худалдаа	Тоо толгой (ширхэг)	Төлвөл зохих Мөнгөн дүн (төгрөгөөр)
1	2	3	4	5	6
1	"Монголиа адвентур аутфиттерс" ХХК	Тул загас болон бусад загас	1-р багц	10 ш, 100ш	897,600
2	"Монголиа адвентур аутфиттерс" ХХК	Тул загас болон бусад загас	2-р багц	10 ш, 100ш	4,400,000
3	Иргэн Элдэв-Очир овогтой Отгонбаяр	Тул загас болон бусад загас	3-р багц	10 ш, 100ш	900,000